

## ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД САНААЧЛАГЫН СЭЛЭНГЭ АЙМГИЙН ДЭД ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

“ЖЭМР” ХХК-тай хамтран орон нутгийн хөгжлийн сангийн 150 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Ногоон хөгжлийн бодлого-2030” бодлогын баримт бичгийг 5 зорилтын 238 үйл ажиллагаа хэрэгжүүлэх боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны 13 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Аймгийн Тагнуулын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Цагдаагийн газар, Татварын газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын




газартай хамтран З удаагийн хяналт шалгалтыг Ерөө сумын “Их алт” гэх газар Ерөө голын мөс цөмлөн олборлолт явуулсан иргэдэд холбогдох зөрчил, Бугант тосгоны Залтын аманд Ерөө сумын иргэн хууль бусаар ашигт малтмал олборлож байсан зөрчил, бичил уурхайгаар үйл ажиллагаа явуулах зорилготой Улаан хясаа гэх газарт байрласан нөхөрлөл бичиг баримтын бүрдэл хангагдаагүй зэрэг зөрчлийг илрүүлж албадан буулгах арга хэмжээ авсан.

Ерөө сумын Бугант багийн Их алтны “Зүр хүзүү” уулын ар хэсэгт Ерөө голын эрэг дагуу болон гол дотор Бугант тосгоны харьят нэр бүхий иргэд нь хууль бусаар алт олборлож гол бохирдуулсан зөрчлийг илрүүлэн Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн.

Уул уурхайн аж ахуйн нэгжийн хөрөнгөөр 200 га талбайд ойжуулалтын ажлыг хийж, Шаамар сумын нутаг дэвсгэрт 100 га талбайд “Номгон форестри” ХХК Канад улсын туршилтаар дроноор бөмбөлөгөөр ойжуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.



“Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээний хүрээнд эвдэрч эзэнгүй орхигдсон ашигт малтмал олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон Баянгол сумын



“Их ташир”, “Цагаан чулуут”, “Наран”, “Нэргүйн хөндий”, “Бага мухар”, Ерөө суманд “Хандгайт”, “Баянгол”, “Толгойт”, “Цагаан толгойт”, Шаамар, Зүүнбүрэн, Түшиг чиглэл, Түшиг суманд “Баруун хужирт”, Хүдэр суманд “Амж” гэх газруудад техникийн нөхөн сэргээлтийг 121,93 га талбайд, биологийн нөхөн сэргээлтийг 51,8 га талбайд хийж, өмнөх оныхоос 54,94 га-гаар нэмэгдүүлсэн.

Аймгийн хэмжээнд “Бугант нандин” ХХК, “Тод ундрата” ХХК, “Цемент шохой” ХХК, “Болдтөмөр Ерөө гол” ХХК, “Инфинити спейс” ХХК, “Чамин-Алт” ХХК, “Ди зэт энд ай” ХХК-иуд нь Бугант тосгоны “Их өлөнтийн аманд”, “Сонор трейд” ХХК Баянгол сумын “Цагаан чулуут”-д, Сайхан сумын “Цемент Шохой” ХХК, Хүдэр сумын “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-иудын санхүүжилтээр “Эв энержи” ХХК Хүдэр сумын “Амж” гэх газарт биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах ажлыг 110,1 га талбайд хийж гүйцэтгэсэн.



“Болд төмөр Ерөө гол” ХХК, “Инфинити Спэйс” ХХК компаниуд 13,4 га, “Хилийн үйлчилгээг сайжруулах бус нутгийн төсөл”-ийн хүрээнд хийгдсэн 1,7 км авто зам барих үйл ажиллагаа карьерт ашигласан 13 га талбай, Алтанбулаг-Дархан чиглэлийн автозамаас Шаамар-Түшиг чиглэлд тавигдсан 120 км замд ашигласан карьери 75.03 га талбайд нөхөн сэргээлтийг хийж, мэдээллийн санд оруулсан.

Монгол улсын Засгийн газрын 2022 оны 296 тоот тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” хэрэгжиж эхэлснээс хойш Ашигт

малтмал, газрын тосны газраас бичил уурхайгаар ашигт малтмал олборлох 68.73 га талбайн 8 дүгнэлт гарсан байна.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод санаачлагын албатай хамтран “Хариуцлагатай бичил уул уурхайн эрхзүйн орчинг сайжруулах сургалт”-нд 25 холбогдох албаны төлөөллийг оролцуулан зохион байгуулсан.

Аймгийн Байгаль орчны газар, цагдаагийн газартай хамтран “Хууль бус уул уурхайгаас урьдчилан сэргийлэх сургалт”-ыг 17 сумын 35 албаны төлөөлөл, бичил уурхай эрхлэгч нөхөрлөлийн гишүүдийг хамруулан зохион байгуулсан.

Орон нутгийн төсөвт ашигт малтмал, газрын тосны хайгуул, олборлолт эрхэлдэг томоохон 24 аж ахуйн нэгжийн 26.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн барьцаа, албан татвар, хураамжийн орлогын 2024 оны тайланг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын ажлын албаны цахим тайлагналтын системд шивж оруулсан.

Аймгийн хэмжээнд 138 ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж, дотоодын нийт бүтээгдэхүүний 39.3 хувийг уул уурхайн салбар бурдуулж, аймгийн төсвийн орлого 30.8 тэрбум төгрөг буюу 40 хувийг уул уурхайн салбараас төвлөрүүлсэн байна.

.....оOо.....